



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2020 оны 12 сарын 17 өдөр

Дугаар 695

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Дарханы дулааны цахилгаан станц" ТӨХК-ийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 212,144,594.00 /хоёр зуун арван хоёр сая нэг зуун дөчин дөрвөн мянга таван зуун ерэн дөрвөн/ төгрөгийн балансын үнэ, 150,616,593.00 (нэг зуун тавин сая зургаан зуун арван зургаан мянга таван зуун ерэн гурав) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан автомашиныг Дархан-Уул аймгийн Мэргэжлийн хяналтын газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Дархан-Уул аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга Д.Бат-Эрдэнэ, "Дарханы дулааны цахилгаан станц" ТӨХК-ийн гүйцэтгэх захирал М.Жаргалсайхан нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн
695... дугаар тогтоолын хавсрал

**"Дарханы дулааны цахилгаан станц" ТӨХК-ийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй
Дархан-Уул аймгийн Мэргэжлийн хяналтын газарт балансаас балансад шилжүүлэх
автомашин**

№	Хөрөнгийн нэр	Үйлдвэрлэсэн, ашиглалтанд орсон он	Нийт балансын үнэ, (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Ланд круйзер суудлын автомашин улсын дугаар 80-08 ДАХ, арлын дугаар JTMH09J2B5054327	2011/2020	212,144,594.00	150,616,593.00	61,528,001.00
2	Нийт дүн		/хоёр зуун арван хоёр сая нэг зуун дөчин дөрвөн мянга таван зуун ерэн дөрөв/	/нэг зуун тавин сая зургаан зуун арван зургаан мянга таван зуун ерэн гурав/	/жаран нэгэн сая таван зуун хорин найман мянга нэгэн/ гурав/